

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХААР УЛСЫН
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ЖУРМЫН ДАГУУ
ЗАРЦУУЛСАН БАЙНА”**

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/06-ШТА-НА

**Хөвсгөл аймаг
2024 он**

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг: mandakhnaranl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
https://audit.mn/?page_id=579

АГУУЛГА



Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

Г.Ичинхорлоо

Аудитор

Л.Мандахнаран

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3
давхар

Цахим хаяг:

audit.mn/?page_id=579

2024 оны 08 дугаар сар

Товчилсон үгийн тайлбар

Аудитын тайлан баталгаажуулах тушаал

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх, аудитын зорилт, хамрах хүрээ, аудитын арга зүй

Ерөнхий мэдээлэл

Бүлэг 1. Улсын Их Хурлын сонгууль зохион байгуулахаар баталсан төсвийг хууль журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

1.1. Санхүүжилтийн хуваарийг журмын дагуу зардлын нэр төрлөөр төлөвлөж баталсан байна.

1.2 Улсын төсвөөс олгосон санхүүжилтийг журамд заасан үзүүлэлтийг харгалзан сумдад хуваарилсан байна.

1.3. Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газарт хуваарилсан төсвийг хэсгийн хорооны тоо, сонгогчийн тоо зэргийг харгалзан төлөвлөсөн байна.

Бүлэг 2. Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг журмын дагуу тайлагнасан байна.

2.1 Сонгуулийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, 3,566.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

2.3 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт үр дүнтэй байна.

Дүгнэлт

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УИХ	Улсын Их Хурал
МТБ	Мэдээлэл технологийн баг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2024 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/27

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/162 дугаар тушаал, 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах” нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороонд тус тус хүргүүлсүгэй.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-т даалгасугай.
4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /ахлах аудитор Г.Ичинхорлоо/-д үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дах заалт, Улсын их хурлын төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Улсын Их Хурлын 2024 оны сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг аймгийн Сонгуулийн хороо болон холбогдох албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг журам зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
- УИХ-ын сонгууль зохион байгуулахтай улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг аймаг, сумын сонгуулийн хороод, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газарт Улсын их хурлын сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс хуваарилсан зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт–Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, лавлагаа авах, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хууль
- СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих журам”
- СЕХ-ноос батлан гаргасан бусад дүрэм, журам, заавар
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах Г.Ичинхорлоо, аудитор Л.Мандахнаран нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрөөс 8 дугаар сарын 10-ний өдрийн дотор хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар 78 гишүүнийг олныг төлөөлөх аргаар, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгож 126 гишүүнтэй байхаар 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн Улсын Их Хурлын хуралдаанаар өөрчлөн найруулсан байна.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 04 дүгээр сарын 16 –ний өдрийн 23 дугаар тогтоолоор Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Сумдын Сонгуулийн хороог Хөвсгөл аймгийн Сонгуулийн хорооны 2024.04.30-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулсан байна.

Хөвсгөл аймагт Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийг зохион байгуулахаар нийт 1825 төрийн албан хаагч ажилласан байна. Үүнд:

- Аймгийн Сонгуулийн хороонд 12 ажилтан;
- Мэдээлэл технологийн багт 5 ажилтан;
- Сумын сонгуулийн хороонд 161 ажилтан;
- Хэсгийн хороодод 1149 ажилтан;
- Мэдээлэл технологийн 154 даамал;
- Иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан 143;
- Цагдаагийн байгууллагын албан хаагч 201;

Хөвсгөл аймагт Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулахаар нийт 1,514,849.0 мянган төгрөгийн зардлыг улсын төсвөөс хуваарилсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1

№	Байгууллагын нэр	Санхүүжилт олгосон байгууллага	Санхүүжсэн дүн	/мян.төг/	
				Зарцуулалт	Үлдэгдэл
1	Аймгийн Сонгуулийн хороо	Сонгуулийн ерөнхий хороо	1,319,717.0	1,316,150.2	3,566.8
2	Улсын бүртгэлийн газар	Улсын бүртгэлийн ерөнхий газар	128,214.0	128,214.0	0.0
3	Цагдаагийн газар	Цагдаагийн ерөнхий газар	66,918.0	66,918.0	0.0
НИЙТ			1,514,849.0	1,511,282.2	3,566.8

Сонгууль зохион байгуулахаар улсын төсвөөс баталсан хөрөнгөөс аймгийн Сонгуулийн хороо нь 3,566.8 мянган төгрөгийг хэмнэж, Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ 1:

Улсын Их Хурлын сонгууль зохион байгуулахаар баталсан төсвийг хууль журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

1.1 Улсын Их Хурлын сонгууль зохион байгуулах төсвийг журмын дагуу зардлын нэр төрлөөр төлөвлөж баталсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.1¹ дэх заалтын дагуу сонгогчийн тоо, сумын хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудыг тоог харгалзан улсын төсвөөс олгох Монгол

¹ Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу сонгогчийн тоо, сум дүүргийн болон хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоог харгалзан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хуваарилна.

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулах зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын 2024 оны А/45 дугаар тушаалаар баталсан ба дараах хуваарийн дагуу санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

Хүснэгт №2

№	Байгууллага	Албан бичгийн дугаар	Мөнгөн дүн /мян. төг/
1	Сонгуулийн ерөнхий хороо	2024.04.16 №3/229	13,647.0
2	Сонгуулийн ерөнхий хороо	2024.05.02 №3/290	176,630.0
3	Сонгуулийн ерөнхий хороо	2024.05.21 №3/373	47,990.0
4	Сонгуулийн ерөнхий хороо	2024.06.09 №3/472	62,894.0
5	Сонгуулийн ерөнхий хороо	2024.06.18 №3/562	1,018,556.0
Нийт			1,319,717.0

Улсын Их Хурлын ээлжит сонгууль зохион байгуулах зардлыг Сонгуулийн ерөнхий хорооноос Хөвсгөл аймагт 1,319,717.0 мянган төгрөгөөр хуваарилсан байна. Санхүүжилтийн хуваарийг “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.2² дахь заалтын дагуу зардлын нэр төрлөөр төлөвлөж баталсан байна.

1.2 Улсын төсвөөс олгосон санхүүжилтийг журамд заасан үзүүлэлтийг харгалзан сумдад хуваарилсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилан ирүүлсэн санхүүжилтийг аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.3 “Аймаг нийслэлийн сонгуулийн хороо, төв комисс Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн тайлбар аргачлал, байгуулагдсан сум дүүргийн болон хэсгийн хорооны тоо, түүнд ажиллах гишүүдийн тоог харгалзан сум дүүргийн сонгуулийн хороо, салбар комисст дараах зардлыг хуваарилна” гэсэн заалтын дагуу сумын хэсгийн хорооны тоо болон түүнд ажиллах гишүүдийн тоог харгалзан сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн аргачлал, зөвлөмжийн дагуу аймаг, сумдын сонгуулийн хороодод дараах байдлаар хуваарилсан байна.

Хүснэгт №3

№	Сумын нэр	Мөнгөн дүн /мян.төг/	Хувь
1	Аймгийн Сонгуулийн хороо	104,441.0	7.9
2	Сумдын сонгуулийн хороо	1,215,276.0	92.1
ДҮН		1,319,717.0	100.0

Аймгийн Сонгуулийн хорооны даргын 6 удаагийн захирамжаар сумдын сонгуулийн хороонд 1,215,276.0 мянган төгрөг, аймгийн Сонгуулийн хороонд

104,441.0 мянган төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодод баталсан санхүүжилтийг олгохдоо тухай бүр заавар, зөвлөмжийг өгч ажилласан байна.

1.3 Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газарт ирүүлсэн төсвийг хэсгийн хорооны тоо, сонгогчийн тоо зэргийг харгалзан төлөвлөсөн байна.

Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг зохион байгуулахаар Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газарт улсын төсвөөс дараах санхүүжилтийг хуваарилсан байна. Үүнд:

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны А/24 дүгээр тушаалаар 122,414.0 мянган төгрөг, 2024 оны А/104 дүгээр тушаалаар 5,800.0 мянган төгрөгийг нийт 128,214.0 мянган төгрөг,

² Сонгуулийн ерөнхий хороо нь аймаг нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст дараах зардлыг хуваарилна.

- Цагдаагийн ерөнхий газрын санхүү, ар талын албаны даргын 2024 оны 6 дугаар 03-ны өдрийн 16/1911 тоот албан бичгээр 66,918.0 мянган төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газарт хуваарилсан зардлыг Хөвсгөл аймгийн сонгогчийн тоо, хэсгийн хороодын тоо, алслалтын хэмжээ зэргийг харгалзан төлөвлөж хуваарилсан байна.

БҮЛЭГ 2:

Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг журмын дагуу тайлагнасан байна.

2.1 Сонгуулийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, 3,566.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн сонгуулийн тойргийн хороо болон сумдын хэсгийн хороод нь санхүүжсэн хөрөнгийг зарцуулахдаа Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.2³ заалт болон Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн төсвийн зарцуулалтын тухай тайлбарыг баримталсан байна.

Хөвсгөл аймагт Улсын Их Хурлын ээлжит сонгууль зохион байгуулах зардлаас 3,566.0 мянган төгрөг хэмнэж СЕХ-д төвлөрүүлсэн байна. Үүнд:

/Хүснэгт-4/		
д/д	Хэсгийн хорооны нэр	Дүн /мян. төгрөг/
1	Аймгийн сонгуулийн хороо	2,846.8
2	Тариалан сумын сонгуулийн хороо	720.0
Нийт дүн		3,566.8

Аймгийн Сонгуулийн хороо нь 7 нэр төрлийн зардлаас 2,846.8 мянган төгрөг, Тариалан сумын

Сонгуулийн хороо нь болзошгүй зардлаас 720.0 мянган төгрөгийг тус тус зарцуулаагүй байна.

Төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа /бичиг хэргийн материал, унаа, сурталчилгааны зардал, маягт хэвлүүлэх зардал/ шууд худалдан авалтаар гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажилласан байна.

Аудитын хугацаанд аймгийн сонгуулийн хороо болон сумдын сонгуулийн хорооны зардлын тайлан, санхүүгийн анхан шатны баримт материалыг татаж үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Аймгийн Сонгуулийн хороо нь Улсын их хурлын ээлжит сонгуулийн хугацаанд мэдээ мэдээллийг иргэдэд нээлттэй хүргэх зорилгоор сурталчилгаа хийхээр мэдээллийн хэрэгслүүдтэй байгуулсан гэрээг дүгнээгүй байсныг аудитын хугацаанд залрууллаа.

Сумдын зардлын гүйцэтгэлийн тайланг хянаж үзэхэд Цагааннуур, Цагаан-Үүр сумдын сонгуулийн хороо нь аймгийн Сонгуулийн хорооноос баталж ирүүлсэн төсвийг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5

					/мян.төг/
№	Сонгуулийн хорооны нэр	Зардлын зүйл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт/хэмнэлт
1	Цагааннуур сум	Бичиг хэрэг	390.0	787.3	-397.3
2		Унааны зардал	1,890.0	1,196.2	693.8
3		Санал авах байр бэлтгэх	620.0	916.5	-296.5

³ Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комисс, салбар комиссын дарга нь тухай сонгуулийн хорооны зардлын дансны 1 дүгээр гарын үсгийг, сонгуулийн хорооны даргын захирамжаар томилогдсон нягтлан бодогч нь 2 дугаар гарын үсгийг зурж, энэ журмын 2.2, 2.3 дах хэсэгт заасан хуваарилсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулна.

4	Цагаан-Үүр сум	Бичиг хэрэг	630.0	538.0	92.0
5		Санал авах байр бэлтгэх	1,240.0	1,332.0	-92.0
		ДҮН	4,770.0	4,770.0	0.0

Цагааннуур сумын сонгуулийн хороо нь 693.8 мянган төгрөгийг, Цагаан-Үүр сумын сонгуулийн хороо нь 92.0 мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Цагааннуур, Цагаан-Үүр сумаас бусад сумдын сонгуулийн хороо нь Улсын Их Хурлын сонгууль зохион байгуулахаар улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг батлагдсан төсвийн дагуу зарцуулсан байна.

2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

Улсын Их Хурлын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг аймгийн сонгуулийн хороо Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.1 дэх хэсэгт “Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө” гэж заасны дагуу сонгуулийн зардлын гүйцэтгэлийг тайлагнасан байна.

Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны зардлын тайланг Сонгуулийн Ерөнхий Хорооны 2021 оны А/17 дугаар “Сонгуулийн төсөв хуваарилах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу нэгтгэн авч, тус журмын 2 дугаар хавсралтын дагуу аймгийн сонгуулийн хорооны зардлын нэгдсэн тайлан гаргасан байна.

Нэгдсэн тайлангийн зардлыг зүйл тус бүрээр харуулбал дараах байдалтай байна.

Аймгийн сонгуулийн хорооны зардлын тайлан

Хүснэгт 6

Д/д	Зардлын нэр	/мян.төгрөгөөр/		
		Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	40.0	33.0	7.0
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	13,347.0	13,234.0	113.0
3	МТБ, даамлын сургалт	28,230.0	28,069.2	160.8
4	Бичиг хэргийн зардал	21,038.0	21,024.2	13.8
5	Шуудан холбооны зардал	23,800.0	23,800.0	-
6	Унааны зардал	103,383.5	103,383.5	-
7	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	40,378.5	40,378.5	-
8	Сурталчилгаа	8,000.0	8,000.0	-
9	Саналын хуудас төхөөрөмж авах, хүргэх ачаа томилолтын зардал	61,594.0	60,622.4	971.6
10	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,300.0	1,300.0	-
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	813,120.0	813,120.0	-
12	Мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	97,944.0	97,944.0	-
13	Хоолны зардал	73,950.0	73,950.0	-
14	Томилолтын зардал	15,932.0	15,107.4	824.6
15	Шуурхай багийн зардал	2,780.0	2,780.0	-
16	Болзошгүй зардал	14,880.0	13,404.0	1,476.0
	НИЙТ ДҮН	1,319,717.0	1,316,150.2	3,566.8

Дээрх хүснэгтээс харахад сонгууль зохион байгуулахад гарсан зардлын нэр төрөл нь Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 тоот захирамжаар баталсан

“Сонгуулийн төсөв хуваарилах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.2⁴-т заасан зардлын нэр төрөлтэй нийцэж байна. Нийт сонгуулийн зардлын 74.8%-ийг сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын мөнгөн урамшуулал, хоолны зардал эзэлж байна.

Улсын их хурлын ээлжит сонгууль зохион байгуулах зардлыг Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газрын нэмэлт санхүүжилтийн дансаар олгож журмын дагуу зарцуулсан байна.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн сонгууль зохион байгуулсан зардлын гүйцэтгэлийг харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 7

д/д	Зардлын нэр	/мян.төг/		
		Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Улсын бүртгэлийн ажилтны мөнгөн урамшуулал, НДШ-ийн зардал	82,956.5	82,956.5	-
2	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, зардал	5,493.5	5,493.5	-
3	Сонгогчдын нэрийн жагсаалт хүргэх зардал	2,262.0	2,262.0	-
4	Томилолт унааны зардал	19,126.0	19,126.0	-
5	Сургалтын бусад зардал	2,640.0	2,640.0	-
6	Техник хэрэгслийг тээвэрлэх зардал	9,336.0	9,336.0	-
7	Шуурхай багийн зардал	600.0	600.0	-
8	Тоног төхөөрөмжийн туршилт	5,800.0	5,800.0	-
ДҮН		128,214.0	128,214.0	

Нийт зардлын 64.7 хувийг улсын бүртгэлийн ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны урамшуулал эзэлж байна. Улсын бүртгэлийн хэлтэс нь Улсын Их Хурлын сонгууль зохион байгуулахаар батлагдсан зардлыг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Аймгийн Цагдаагийн газрын сонгууль зохион байгуулсан зардлын гүйцэтгэлийг харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 8

д/д	Зардлын нэр	/мян.төг/		
		Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Цагдаагийн ажилтны хоолны мөнгө	30,048.0	30,048.0	-
2	Шатахууны зардал	3,000.0	3,000.0	-
3	Шуудан холбооны зардал	14,970.0	14,970.0	-
4	Томилолтын зардал	18,900.0	18,900.0	-
ДҮН		66,918.0	66,918.0	

Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар нь Улсын Их Хурлын сонгууль зохион байгуулахаар батлагдсан зардлыг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Аймаг, сумдын сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газар нь Улсын Их Хурлын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлыг хууль, журмын дагуу гаргаж тайлагнасан байна.

2.3 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт үр дүнтэй байна.

Хөвсгөл аймгийн Сонгуулийн хорооны 100170022001 тоот дансны 1 дүгээр гарын үсгийг сонгуулийн хорооны дарга Б.Батбилгүүн, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Мөнхзул нар зурж, санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан байна.

⁴ Сонгуулийн ерөнхий хороо нь аймаг нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст дараах зардлыг хуваарилна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.10 дахь хэсэгт заасны дагуу аймгийн Сонгуулийн хороо сумын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад хяналт тавьж, дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

1. Аймгийн сонгуулийн хороо нь Сумын сонгуулийн хороонд санхүүжилт олгох бүртээ хөрөнгө зарцуулах талаар тайлбар, зөвлөмжүүдийг хүргүүлсэн байна.
2. Аймгийн сонгуулийн хорооны гишүүдэд сумын сонгуулийн хороог хариуцуулан удирдлага арга зүйгээр хангаж ажилласан байна.
3. Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үйл ажиллагаанд улсын төсвөөс хуваарилсан санхүүжилтэд аймаг сумдын төрийн санд түр данс нээж, төсвийг хуваарилан, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээгээр нь зардлын эрхийг нээж хяналт тавьж ажилласан байна. Аймаг, сумдын сонгуулийн зардлын баримт материалыг архивын нэгж болгон үдэж цэгцэлсэн байна.
4. Аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороодод төсөв зарцуулалт болон бүрдүүлэх анхан шатны баримт, урамшуулал, унаа хоолны мөнгө, томилолтын зардал тооцох зэрэгт нэгдсэн тайлбар чиглэлийг хүргүүлэн ажилласан байна.
5. Сонгуулийн хорооны мэдээллийг ил тод байлгах үүднээс аймгийн сонгуулийн хорооноос гарсан тогтоол, зөвлөмж шийдвэрүүдийг бүх сумдын сонгуулийн хороодод хүргүүлж, аймгийн сонгуулийн хорооны facebook – т тухай бүр нь тавьж ажилласан байна. Мөн Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай сонгуулийн хугацаанд хамтран ажиллах гэрээ байгуулж, сонгуулийн үйл ажиллагааг ард иргэдэд сурталчлан таниулж, холбогдох мэдээллийг цаг тухай бүр хүргэж ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Улсын Их Хурлын ээлжит сонгууль зохион байгуулахаар батлагдсан төсвийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.
2. Улсын Их Хурлын сонгууль зохион байгуулахаар улсын төсвөөс хуваарилсан зардлын гүйцэтгэлийг журмын дагуу тайлагнаж 3,566.8 мянган төгрөгийг хэмнэж, буцаан төвлөрүүлсэн байна.
3. Цагааннуур, Цагаан-Үүр сумдаас бусад сумдын Сонгуулийн хороо нь Улсын Их Хурлын сонгууль зохион байгуулахаар хуваарилсан зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулсан байна.
4. Аймаг сумдын сонгуулийн хорооны зардлын нэгдсэн тайланг “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын хавсралтын дагуу тайлагнаж, хөрөнгийн зарцуулалтад аймаг сумдын төрийн сангаар дамжуулан хяналтыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл хөтөлж, анхан шатны баримтыг бүрдүүлж ажилласан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын
2021 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн
А/17 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ
СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН НЭГТГЭЛ**

2024.07.09				төгрөг
№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	40,000	33,000	7,000
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	13,347,000	13,234,000	113,000
3	МТБ, даамлын сургалт	28,230,000	28,069,200	160,800
4	Бичиг хэргийн зардал	21,038,000	21,024,200	13,800
5	Шуудан холбооны зардал	23,800,000	23,800,000	-
6	Унааны зардал	103,383,500	103,383,500	-
7	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	40,378,500	40,378,500	-
8	Сурталчилгаа	8,000,000	8,000,000	-
9	Саналын хуудас төхөөрөмж авах, хүргэх ачаа томилолтын зардал	61,594,000	60,622,400	971,600
10	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,300,000	1,300,000	-
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	813,120,000	813,120,000	-
12	Мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	97,944,000	97,944,000	-
13	Хоолны зардал	73,950,000	73,950,000	-
14	Томилолтын зардал	15,932,000	15,107,400	824,600
15	Шуурхай багийн зардал	2,780,000	2,780,000	-
16	Болзошгүй зардал	14,880,000	13,404,000	1,476,000
ДҮН		1,319,717,000	1,316,150,200	3,566,800

ТАЙЛАН ГАРГАСАН:

Цагаан-Уул сумын сонгуулийн хороо

Дарга /Б.Батбилгүүн/

Нягтлан бодогч /Б.Мөнхзул/

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**

АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас: 7038 2300, 7038 3303, факс: 7038 1001
Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn
Цахим хуудас: www.khovsgol.gov.mn

2024.08.08 № 036
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 2024 оны сонгуулийн зардлын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төслийг хүлээн зөвшөөрч байна.

ДАРГА  Б.БАТБИЛГҮҮН